


ЗӨВШӨӨРӨВ:

ЭМНЭЛГИЙН МЭРГЭЖИЛТНИЙ
ХӨГЖЛИЙН ЗӨВЛӨЛИЙН ДАРГА



БАТЛАВ:

ЭРҮҮЛ МЭНДИЙН ЯАМНЫ ДЭРГЭДЭХ
УЛАМЖЛАЛТ АНАГААХ УХААН СУДЛАЛЫН
МЭРГЭЖЛИЙН САЛБАР ЗӨВЛӨЛИЙН
ДАРГА



УЛАМЖЛАЛТ АНАГААХ УХААНЫ ИХ ЭМЧИЙН
“МОНГОЛЫН УЛАМЖЛАЛТ АНАГААХ УХААНЫ
ДОТОР СУДЛАЛ”
ҮНДСЭН МЭРГЭШЛИЙН СУРГАЛТЫН ХӨТӨЛБӨР

Мэргэшлийн индекс: S(r) 091703

Сургалтын хугацаа: 2 жил

УЛААНБААТАР ХОТ
2022 ОН

БОЛОВСРУУЛСАН АЖЛЫН ХЭСЭГ:

С.Хишигжаргал	Анагаахын Шинжлэх Ухааны Үндэсний Их Сургууль, Монгол Анагаах Ухааны Олон Улсын сургуулийн Дотор өвчин судлалын тэнхимийн эрхлэгч, Анагаах ухааны доктор, профессор, Уламжлалт анагаах ухааны зөвлөх зэргийн эмч
С.Сээсрэгдорж	Анагаахын Шинжлэх Ухааны Үндэсний Их Сургууль, Монгол Анагаах Ухааны Олон Улсын сургуулийн Дотор өвчин судлалын тэнхимийн багш, Анагаах ухааны доктор, профессор, Уламжлалт анагаах ухааны зөвлөх зэргийн эмч
П.Молор-Эрдэнэ	Анагаахын Шинжлэх Ухааны Үндэсний Их Сургууль, Монгол Анагаах Ухааны Олон Улсын сургуулийн Дотор өвчин судлалын тэнхимийн багш, Анагаах ухааны доктор, дэд профессор, Уламжлалт анагаах ухааны тэргүүлэх зэргийн эмч
Н.Оюунцэцэг	Анагаахын Шинжлэх Ухааны Үндэсний Их Сургууль, Монгол Анагаах Ухааны Олон Улсын сургуулийн Уламжлалт эмчилгээний тэнхимийн эрхлэгч, Анагаах ухааны доктор, дэд профессор, Уламжлалт анагаах ухааны зөвлөх зэргийн эмч
Б.Цэрэнцоо	Анагаахын Шинжлэх Ухааны Үндэсний Их Сургууль, Монгол Анагаах Ухааны Олон Улсын сургуулийн Уламжлалт жор судлалын тэнхимийн эрхлэгч, Анагаах ухааны доктор, дэд профессор, Уламжлалт анагаах ухааны тэргүүлэх зэргийн эмч
Т.Алимаа	Анагаахын Шинжлэх Ухааны Үндэсний Их Сургууль, Монгол Анагаах Ухааны Олон Улсын сургуулийн Монгол анагаах ухаан судлалын тэнхимийн багш, Анагаах ухааны доктор, дэд профессор, Уламжлалт анагаах ухааны тэргүүлэх зэргийн эмч
Э.Уранбайгаль	Анагаахын Шинжлэх Ухааны Үндэсний Их Сургууль, Анагаах Ухааны сургуулийн лабораторийн тэнхимийн багш, Анагаах ухааны доктор
Ж.Батноров	Уламжлалт Анагаах Ухаан Технологийн Хүрээлэнгийн эмч, Анагаах Ухааны магистр, Уламжлалт анагаах ухааны тэргүүлэх зэргийн эмч
Ж.Мөнхбат	Уламжлалт Анагаах Ухаан Технологийн Хүрээлэнгийн эмч, Анагаах Ухааны магистр Уламжлалт анагаах ухааны тэргүүлэх зэргийн эмч
Б.Ундрахтамир	Мамба Дацан Нэгдсэн эмнэлгийн эмч, Анагаах Ухааны магистр

ХАМТРАН АЖИЛЛАСАН:

Уламжлалт Анагаах Ухаан Технологийн Хүрээлэн

Ч.Чимэдрагчаа	Уламжлалт Анагаах Ухаан Технологийн Хүрээлэнгийн захирал, Анагаахын Шинжлэх Ухааны доктор, профессор, Уламжлалт анагаах ухааны зөвлөх зэргийн эмч
Д.Шинэтуяа	Уламжлалт Анагаах Ухаан Технологийн Хүрээлэн, Төгсөлтийн дараах сургалтын албаны дарга, Анагаах ухааны магистр, Зүү эмчилгээний зөвлөх зэргийн эмч

Анагаахын Шинжлэх Ухааны Үндэсний Их Сургууль

Д.Цэнд-Аюуш	Уламжлалт анагаах ухаан судлалын мэргэжлийн салбар зөвлөлийн ерөнхий мэргэжилтэн, Анагаахын Шинжлэх Ухааны Үндэсний Их Сургууль, Монгол Анагаах Ухааны Олон Улсын сургуулийн захирал, Анагаах ухааны доктор, профессор
Н.Занди	Анагаахын Шинжлэх Ухааны Үндэсний Их Сургууль, Монгол Анагаах Ухааны Олон Улсын сургуулийн Уламжлалт эмчилгээний тэнхимийн багш, Анагаах ухааны доктор, Уламжлалт анагаах ухааны тэргүүлэх зэргийн эмч

ХЯНАСАН:

П.Эрхэмбаяр	Эрүүл мэндийн яамны Төрийн захиргааны удирдлагын газрын дарга, Нийгмийн эрүүл мэндийн магистр
Б.Туяа	Эрүүл мэндийн яамны Төрийн захиргааны удирдлагын газрын мэргэжилтэн
Д.Дондогмаа	Эрүүл мэндийн хөгжлийн төвийн Хүний нөөцийн хөгжлийн албаны ахлах мэргэжилтэн, Анагаах ухааны магистр
М.Оюунчимэг	Эрүүл мэндийн яамны Эмнэлгийн тусламж, үйлчилгээний газрын Уламжлалт анагаах ухааны хэлтсийн Уламжлалт анагаах ухааны тусламж үйлчилгээ хариуцсан ахлах шинжээч

Эмнэлгийн мэргэжилтний хөгжлийн зөвлөлийн
2022 оны 09-р сарын 23-ны өдрийн
27 дугаар тогтоолоор зөвшөөрөв.

УЛАМЖЛАЛТ АНАГААХ УХААНЫ ИХ ЭМЧИЙН
“МОНГОЛЫН УЛАМЖЛАЛТ АНАГААХ УХААНЫ ДОТОР СУДЛАЛ”
ҮНДСЭН МЭРГЭШЛИЙН СУРГАЛТЫН ХӨТӨЛБӨР

НЭГ. ҮНДЭСЛЭЛ

Уламжлалт анагаах ухааны тусламж үйлчилгээ үзүүлж байгаа эмнэлгийн байгууллагад ажиллаж буй уламжлалт анагаах ухааны их эмч нарын мэдлэг, чадвар, хандлагыг шинжлэх ухааны хөгжил, нийгмийн эрэлт, хэрэгцээнд нийцүүлэн төгсөлтийн дараах сургалтаар тасралтгүй дээшлүүлэх нь чухал юм.

Эрүүл мэндийн байгууллагын 2018 оны хүний нөөцийн мэдээгээр Уламжлалт анагаах ухааны эмч 867, 2021 онд 1142 ажиллаж, нийт эмч нарын 11.1%-ийг эзэлж байна. Уламжлалтын сувилагч 455 байсан бөгөөд улсын дунджаар 10000 хүн амд ноогдох Уламжлалт анагаах ухааны эмч 2.7, сувилагч 1.5 байна.

Дэлхийн анагаах ухааны хөгжлийн чиг хандлага, Монгол хүний өвчлөл, нас баралт, тархалтын судалгаанаас үзэхэд уламжлалт анагаах ухааны оношилгоо, эмчилгээ, урьдчилан сэргийлэх үйлчилгээний чанар, хүртээмжийг нэмэгдүүлэх, мэдлэг, чадвар, зөв харилцаа хандлагатай мэргэшсэн эмч, сувилагч, тусгай мэргэжилтнийг бэлтгэх хэрэгцээ, шаардлага тавигдаж байна.

Иймд “Төгсөлтийн дараах үндсэн ба төрөлжсөн мэргэшлийн сургалтын чиглэл, индекс шинэчлэн батлах тухай” Эрүүл мэндийн сайдын 2021 оны 7 дугаар сарын 7-ны өдрийн А/445 дугаар тушаалаар Уламжлалт анагаах ухааны чиглэлийн 8 үндсэн мэргэшлийн индекс батлагдсан нь төгсөлтийн дараах сургалтад томоохон дэвшил болж, сургалт явагдах эрхзүйн орчин бүрдсэнээр Уламжлалт Анагаах ухааны үндсэн мэргэшлийн “Дотор судлал” сургалтын хөтөлбөрийг боловсруулав.

ХОЁР. ЭРХЭМ ЗОРИЛГО

Хүн амын эрүүл мэндийн хэрэгцээнд нийцэх Уламжлалт анагаах ухааны чиглэлээр анхан шатны чанартай тусламж үзүүлэх, Орчин үеийн анагаах ухаантай хослуулан өвчин эмгэгийг оношлох, эмчлэх аргад суралцсан, эрүүл мэндийн бүх шатлалын эмнэлэгт бие даан ажиллах чадвартай эмч бэлтгэх

ГУРАВ. АЛСЫН ХАРАА

Монголын уламжлалт анагаах ухааны Дотор судлал сургалтын хөтөлбөрөөр бэлтгэх эмчийн дүр зураг:

Хүн амыг уламжлалт анагаах ухаанаар өвчнөөс урьдчилан сэргийлэх, тусламж үйлчилгээ үзүүлэх үүрэг хариуцлагаа бүрэн ойлгосон; зонхилон

тохиолдох өвчний оношилгоо, эм заслын эмчилгээ хийхэд шаардагдах мэдлэг, ур чадварыг эзэмшсэн; үйлчлүүлэгчдэд энэрэх сэтгэлээр хандаж, эмчийн ёс зүйг чандлан баримталдаг, багаар ажиллан эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг үр дүнтэй үзүүлж чаддаг уламжлалт анагаахын эмч байна.

ДӨРӨВ. СУРГАЛТЫН ЗОРИЛТ

Алсын харааг биелүүлэхэд чиглэсэн дараах цөм чадамжтай байна.

1. Монголын уламжлалт анагаахын эмч (*Doctor of traditional medicine*)
2. Суралцагч (*Learner*)
3. Харилцагч (*Communicator*)
4. Хамтрагч (*Collaborator*)
5. Хүн амын эрүүл мэндийн зөвлөгч (*Community health advocate*)
6. Зохион байгуулагч, манлайлагч (*Leader*)

Энэхүү цогц чадамж нь **Монголын уламжлалт анагаах ухааны Дотор судлалын** эмчийг төлөвшүүлэхэд чиглэсэн мэдлэг, чадвар, хандлагын тухай ойлголт юм. Үүнд:

1. Монголын уламжлалт анагаах ухааны дотор судлалаар мэргэшсэн эмч нь

(*Traditional Mongolian Medicine "INTERNAL MEDICINE DOCTOR"*):

- Хүн амын дунд зонхилон тохиолдох дотрын өвчний шинж тэмдгийг уламжлалт болон орчин үеийн анагаах ухааны оношилгооны аргуудыг хэрэглэн ялган таньж оношлох, анхан шатны арга хэмжээг авах.
- Үйлчлүүлэгчээс асуумж авах, бодит үзлэг хийх, үйлчлүүлэгчийн сэтгэл зүйг үнэлж уламжлалт анагаах ухааны аргаар идээ ундаа, явдал мөр, эм, заслын эмчилгээ, хяналтын төлөвлөгөө гаргаж хэрэгжүүлэх.
- Уламжлалт анагаахын заслын аргуудаас өвчин тус бүрд нь тохируулан хийх.
- Уламжлалт Анагаах Ухааны өвчний ангилал зүй, оношийн кодыг эмнэл зүйд ашиглах.
- Уламжлалт анагаах ухааны үндсэн онолыг үндэслэн өвчин эмгэгээс цаг улирал, бие махбодын өвөрмөц чанар, насны байдалтай нь уялдуулан урьдчилан сэргийлэх эрүүлжүүлэх, зөвлөгөө өгөх.
- Орон нутгийн түвшинд хийгдэх оношилгоо, эмчилгээний гардан үйлдлийг бүрэн эзэмшиж, тусламж үйлчилгээг аюулгүй үзүүлэх;
- Орон нутгийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний нөөц бололцоонд тулгуурлан үйлчлүүлэгчид үзүүлэх тусламж үйлчилгээг шийдвэрлэх.
- Үйлчлүүлэгчийн хувийн нууцыг хадгалах.
- Үйлчлүүлэгчийн өвдөлт, сэтгэл зовнилд анхаарал хандуулах.
- Эрүүл мэндийн байгууллагын бүртгэл болон тайлангийн маягыг зохих журмын дагуу цаг хугацаанд нь хөтлөх.

2. Суралцагч байх (*Learner*):

- Өөрийн мэдлэг ур чадвараа дээшлүүлэхийн тулд богино хугацааны мэргэжлийн хэрэгцээт сургалтад хамрагдах
- Бие даан тасралтгүйгээр суралцах, олон төрлийн мэдээллийн эх сурвалжуудыг судлан дүн шинжилгээ хийх
- Мэргэжлээ дээшлүүлэх сургалтуудыг хамтран суралцагч эмч нар болон бусад эмнэлгийн мэргэжилтэнд заах замаар өөрийн мэдлэг, ур чадвараа сайжруулах.
- Эрдэм шинжилгээ, судалгааны арга зүйг эзэмшиж мэргэжлийн нийгэмлэг холбооны болон гадаад дотоодын эрдэм шинжилгээний хуралд илтгэл өгүүлэл хэлэлцүүлэх, хэвлүүлэх.

3. Харилцагч (*Communicator*):

- Үнэнч шударга, хариуцлагатай, нууцыг хадгалан, бусдыг хүндлэн, чин сэтгэлээсээ хандах
- Хувь хүний онцлогийг харгалзан үйлчлүүлэгч болон түүний гэр бүлийн гишүүн, асран хамгаалагч, төрөл, садны хүнтэй зүй зохистой үг хэллэг ашиглан зөв боловсон харилцах.
- Үйлчлүүлэгчид шаардлагатай мэдээлэл өгөхдөө ойлгоход хялбар үг хэллэг ашиглан тайлбарлах.
- Шаардлагатай тохиолдолд үйлчлүүлэгчийн оношилгоо, эмчилгээний талаар бусад эмнэлгийн мэргэжилтэнтэй зөвлөлдөх.

4. Хамтрагч (*Collaborator*) :

- Тухайн орон нутгийн уламжлалт анагаахын тусламж, үйлчилгээтэй холбоотой асуудлаар мэргэшлийн эмч нартай мэдээлэл солилцож, хамтран ажиллах.
- Эмнэлгийн бусад тасгийн эмч, эмнэлгийн мэргэжилтэнтэй мэргэжлийн мэдлэг, мэдээллээ хуваалцаж хамтран ажиллах.
- Эмнэлгийн бусад ажилтан, мэргэжилтэнтэй багаар ажиллах чадвартай байх.

5. Хүн амын эрүүл мэндийн зөвлөгч (*Community health advisor*):

- Хүн амын эрүүл мэндийн зөвлөгч байхын тулд урьдчилан сэргийлэх, тусламж үйлчилгээ үзүүлэх, сургалт сурталчилгаа явуулах.
- Хүн амын эрүүл мэндийн хэрэгцээнд тохирсон арга хэмжээг авч хэрэгжүүлэх.

6. Зохион байгуулагч, манлайлагч (*Leader*):

- Уламжлалт анагаахын тусламж, үйлчилгээг зохицуулах, манлайлан ажиллах.
- Өөрийгөө болон бусдыг хөгжүүлэх, сургах, багаар ажиллах.
- Эмнэлэг, эрүүл мэндийн төв дэх тусламж, үйлчилгээ үзүүлэх багийг түргүүлэн ажиллах.

ТАВ. СУРГАЛТЫН АРГА ЗҮЙ

5.1 Сургалтын чиглэл, хугацаа, байршил

- Сургалт нь Монголын уламжлалт анагаах ухааны онол, Эмнэлгийн төвөд хэл, Монгол эмийн түүхий эд, жор судлал, Монгол анагаах ухааны онош зүй, Монгол анагаах ухааны засал, Лабораторийн арга зүй, Монгол анагаах ухааны дотор өвчин судлал I,II, Яаралтай тусламж, Өвчнөөс урьдчилан сэргийлэх ёс гэсэн 9 тойролтоор явагдах ба заавал судлах Эмнэлгийн мэргэжилтний ёс зүй, харилцаа хандлага, Амилуулах суурь тусламж, Халдварын сэргийлэлт, хяналтын сургалт зэрэг сургалтууд багтана.
- Сургалтын нийт хугацаа 2 жил байна. 1 улирал нь 22 долоо хоног үргэлжилнэ. Сургалтын хугацаанд суралцагч нь жилд 1 сар амарна. Нийт 88 долоо хоног суралцана.
- Тойролтын хугацаа болон сонгон суралцах чиглэл, хугацааг сургалт эрхлэх байгууллага өөрийн онцлог, хүчин чадалд тохируулан зохицуулна.
- Суралцагчийн өдөр тутмын болон 7 хоногийн үйл ажиллагааны тодорхой хуваарийг сургалт эрхлэх байгууллагаас боловсруулна.
- Эмнэл зүйн мэргэшүүлэх сургалт эрхлэх байгууллагад тавигдах шаардлага хангаж, Эмнэлгийн мэргэжилтний хөгжлийн зөвлөлөөс “Монголын уламжлалт анагаах ухааны Дотор судлал” үндсэн мэргэшлийн сургалт эрхлэх зөвшөөрөл авсан эмнэлгийн тусламж, үйлчилгээний байгууллага энэхүү сургалтыг явуулна.
- Нэгдсэн эмнэлэг, эрүүл мэндийн төв нь энэхүү сургалтын үндсэн байгууллага байна. Хэрэв сургалт явуулах хангалттай орчин бүрдээгүй тохиолдол бусад эрүүл мэндийн байгууллагыг оролцуулан сургалт эрхлэх байгууллагын сүлжээ үүсгэн хамтран ажиллана.
- “Монголын уламжлалт анагаах ухааны дотор судлал” үндсэн мэргэшлийн сургалт эрхлэх зөвшөөрөл авсан эмнэлгийн тусламж, үйлчилгээний байгууллагын амбулатори, хэвтэн эмчлүүлэх тасаг, хурлын танхим, сургалтын анги, танхимд сургалт явагдана.
- Сургалт эрхлэх байгууллага дээр зохион байгуулагдаж буй Эмнэлгийн мэргэжилтний ёс зүй, харилцаа, хандлага, Халдварын сэргийлэлт, хяналт, Амилуулах суурь тусламж, Эрүүл мэндийн салбарт мөрдөгдөж буй хууль, журам, зөрчлийн тухай хууль, хувь хүний нууцтай холбоотой хууль, Эмнэлгийн эрх зүйн чиглэлээр сургалтад заавал хамрагдана.

5.2 Зайлшгүй танин мэдэж, суралцах шаардлагатай шинж тэмдэг, өвчин, гардан үйлдэл:

Сургалтын төгсгөлд орон нутагт ганцаараа бие даан уламжлалтын тусламж, үйлчилгээ үзүүлж чадах түвшинд хүрэхийн тулд эмнэл зүйн сургагч багшийн хяналт дор амбулаториор ирэх үйлчлүүлэгч, хэвтэн эмчлүүлэх үйлчлүүлэгчийн оношилгоо, эмчилгээг хариуцан хийх явцдаа дараах шинж тэмдэг, өвчин, гардан үйлдлийг гүйцэтгэж, туршлага хуримтлуулна.

5.2.1 Өвчний шинж тэмдэг-*signs and symptoms* (аль ч тойролтод тохиолдох):

Өвчний түүх, бодит үзлэгт үндэслэн эрэмбэлэн ангилж, ялган оношилгоо хийн, анхан шатны эмчилгээг эхлүүлж чаддаг болох:

1. Толгой өвдөх (*Headache*)
2. Ухаан алдах, балартах (*Altered level of consciousness*)
3. Татах (*Seizure*)
4. Дотор муухайрах, бөөлжих, хоосноор огиулах (*Nauseas, Vomiting*)
5. Нуруу өвдөх (*Back pain*)
6. Хүзүү өвдөх (*Neck pain*)
7. Саажилт (*Paralysis*)
8. Халуурах (*Fever*)
9. Шарлах (*Jaundice*)
10. Амьсгаадах (*Dyspnea*)
11. Ханиалгах, цэр гарах (*Coughing, Sputum excretion*)
12. Цээжээр өвдөх (*Chest pain*)
13. Зүрх зогсох (*Cardiac arrest*)
14. Цустай бөөлжих (*Hematemesis*)
15. Цустай суулгах (*Melena*)
16. Хэвлий өвдөх (*Stomachache*)
17. Суулгах (*Diarrhea*)
18. Шингэн алдах (*Dehydration*)
19. Сэтгэл гутрал (*Depression*)
20. Хаван /цайвар, суваг, усан хаван/ (*Edema*)
21. Үений өвдөлт (*Arthralgia*)
22. Цус алдах (*Hemorrhagic tendency*)
23. Жихүүцэх (*Shivering*)
24. Эвшээх (*Yawning*)
25. Таван мэдрэхүй үл тодрох (*dullness of the sense organs*)
26. Сэтгэл санаа тогтворгүй болох (*Mental instability*)
27. Сүүж бэлхүүс, яс үесээр хатгуулж өвдөх (*stabbing pain in the hips, waist, bones and joints*)
28. Энд тэндгүй тогтворгүй өвдөх (*shifting pain*)
29. Идээ шингэсний дараа, өглөө үүрээр, үдшийн бүрийд өвчин хөдлөх (*arising after digestion, in the evening and around dawn*)
30. Аманд гашуун амт амтагдах (*bitter taste in the mouth*)
31. Идээ шингэх үед өвдөх (*pain during digestion*)
32. Хоолонд дургүй болох (*loss of appetite*)

5.2.2 Зайлшгүй суралцаж, таньж мэдэх шаардлагатай өвчин эмгэгүүд:

1. Хийн өвчин (ТМА00-ТМА03)
2. Шарын өвчин (ТМВ00- ТМВ02)
3. Бадганы өвчин (ТМС00- ТМС03)
4. Хурмал борын өвчин (ТМД00- ТМД04)
5. Эс шингэсэн өвчин (ТМЕ00)
6. Их архаг өвчнүүд (бэтэг ТМЕ01, хаван өвчнүүд ТМЕ02- ТМЕ04)

7. Цусны өвчнүүд (TME06)
8. Шар усны өвчнүүд (TMM15)
9. 5 цул, 6 сав эрхтний өвчнүүд (TMK00-TMK08)
10. Хэсэг бусаг өвчнүүд (TMM00-TMM18)
11. Хамт төрсөн яр өвчнүүд (TMQ00)
12. Эмэгтэйчүүдийн өвчин (TMR00)
13. Ад донгийн өвчин (TMS00-TMS04)
14. Хорын өвчин (TMU00-TMU07)
15. Халуун өвчин (TMF00, TMF01 TMG00-TMG05, TMH00-02)
16. Уламжлалт анагаах ухаанаар хүчжүүлэх, шимжүүлэх (TMW00-TMW02)
17. Өвчнөөс урьдчилан сэргийлэх уламжлалт анагаах ухааны ёс

5.2.3 Гардан үйлдлийн жагсаалт:

1. Зарим өвчний үеийн дом засал тархи доргилт, бэртэл гэмтэл, хорын өвчин, нялхсын өвчинд тохирсон эмчилгээг хийх
2. Өвчний шалтгаан, нөхцөл, бэлгэ чанар, туслах хорлохын үүднээс асуух
3. Үзэх шинжилгээний аргуудаар дан, хавсарсан, хурсан, их архаг, цул савын өвчний үед үйлчлүүлэгчийн сүр сүлд, цог жавхаа, нүүр, царай, бие, арьс, цөв, хир, таван цэцэг зэрэгт гарах өөрчлөлтүүдийг илрүүлэх
4. Шээсийг 3 цаг, 9 ёсоор үзэж шинжлэх
5. Хаванг үзэж шинжлэх
6. Хүрэлцэх шинжилгээгээр дан, хавсарсан, хурсан, их архаг, цул савын өвчний үед бэлчир орон тэмтрэх, судас барих гарах өөрчлөлтүүдийг илрүүлэх
7. Уул тал завсрын халуун, хий шар бадганы гурван боомт, өвчний 10 их баримтлал, өвчнийг шинжлэн тодруулах хэрэгт 4 товчийг оношилгоонд хэрэглэх
8. Зонхилон тохиолдох өвчний ханах засал хийх
9. Харандаан төөнө хийх
10. Монгол төөнө хийх
11. Шивүүр засал хийх
12. Самнуур засал хийх
13. Түрэм засал хийх
14. Зүүлэх төөнө хийх
15. Тогтмол, дахимал, гулгуур бумба тавих
16. Зөгийн балаар татах эмчилгээ хийх
17. Хиймэл 5 рашааныг найруулах, бэлтгэж үйлчлүүлэгчийг оруулах
18. Хүйтэн, халуун жин засал хийх
19. Туулгах засалд үйлчлүүлэгчийг бэлтгэх, туулгах заслыг хийх
20. Бөөлжүүлэх засалд үйлчлүүлэгчийг бэлтгэх, бөөлжүүлэх заслыг хийх
21. Шавар эмчилгээг тохирох хэлбэрээр тавих (бээлий, оймс, урт, богино өмд, мөрөвч, тохойвч, өвдгөвч)
22. Ороох засал хийх
23. Бүх биеийн зөөлөн бариа хийх
24. Шимжүүлэх бариа хийх
25. Зүрх судасны зарим эмгэгүүдийн үед хийх бариа

26. Амьсгалын замын зарим эмгэгүүдийн үед хийх бариа
27. Хоол боловсруулах замын зарим эмгэгүүдийн үед хийх бариа
28. Бөөр, шээсний замын зарим эмгэгүүдийн үед хийх бариа
29. Эмэгтэйчүүдийн зарим эмгэгүүдийн үед хийх бариа
30. Яс булчингийн тогтолцооны зарим эмгэгүүдийн үед хийх бариа
31. Ердийн зүү эмчилгээ хийх
32. Дасгал хөдөлгөөн эмчилгээ хийх
33. Тайвшруулах эмчилгээ хийх
34. Сэтгэл засал эмчилгээ хийх
35. Ургамлын гаралтай хүнсний нэмэлт эмээр эмчлэх

ЗУРГАА. СУРГАЛТЫН АГУУЛГА

Сургалт нийт 88 долоо хоног үргэлжлэх ба заавал судлах, мэргэшүүлэх тойролтуудыг хийж гүйцэтгэсэн байна.

1. Заавал судлах тойролтоор 1 дүгээр дамжаанд 4 долоо хоног сургалтыг сургалт хариуцсан байгууллагын ментор багш, сургагч багш, мэргэжилтнүүд хариуцан зохион байгуулж үр дүнг суралцагчийн дэвтэрт тэмдэглэнэ.
2. Мэргэшүүлэх тойролт нь 1 дүгээр дамжаанд 44 долоо хоног, 2 дугаар дамжаанд 44 долоо хоног байх ба үр дүнг тооцуулсан байна.

Тойролтын хуваарь

№	Тойролтын нэр	Долоо хоног
Заавал судлах /1 долоо хоног/		
1	Амилуулах суурь тусламж	1
2	Эмнэлгийн мэргэжилтний харилцаа хандлага	
3	Халдварын сэргийлэлт, хяналт	
4	Эмнэлгийн хууль эрх зүй	
Мэргэшүүлэх тойролт /87 долоо хоног/		
1	Монгол Анагаах Ухааны онол /5/, эмнэлгийн төвөд хэл /3/	8
2	Монгол эмийн түүхий эд /2/, жор судлал /4/	6
3	Монгол Анагаах Ухааны онош зүй	12
4	Монгол Анагаах Ухааны засал	14
5	Лабораторийн арга зүй	4
6	Монгол Анагаах Ухааны Дотор өвчин I	20
7	Монгол Анагаах Ухааны Дотор өвчин II	18
8	Яаралтай тусламж	3
9	Уламжлалт анагаах ухааны өвчнөөс урьдчилан сэргийлэх ёс	2
	Нийт	88

ТОЙРОЛТ 1. МОНГОЛЫН УЛАМЖЛАЛТ АНАГААХ УХААНЫ ОНОЛ, ТӨВӨД ХЭЛ

1. Уламжлалт анагаах ухааны хөгжлийн түүхэн үе шатууд
2. Уламжлалт анагаах ухааны тулгуур онолууд болох арга билгийн онол, гурван махбодын онол, таван махбодын онол, цул сав эрхтний онол
3. Хөврөл тогтох бойжих ёс
4. Долоон тамир, тунгалаг цөвийн боловсролт
5. Биеийн гүйцэд хэмжээ
6. Биеийн үйл ялгал
7. Өвөрмөц чанар
8. Өвчингүй эрүүл орших ёс
9. Өвчний шалтгаан, нөхцөл, орох ёс, өвчин явагдах үе шат
10. Дөрвөн ерөндгийн тухай ойлголт
11. "Анагаах ухааны дөрвөн үндэс" номын бүтэц, агуулга
12. Язгуурын үндсийн бүлгүүдийг орчуулах
13. Үг, өгүүлбэрийн далд утгыг тайлбарлах
14. Язгуурын үндсийн 9 мод босгох
15. Онолын үндсийн бүлгүүдийн далд утгыг тайлбарлах
16. Онолын үндсийн 4 мод босгох

ТОЙРОЛТ 2. МОНГОЛ ЭМИЙН ТҮҮХИЙ ЭД, ЖОР СУДЛАЛ

Тойролтын агуулга:

1. Зонхилон тохиолдох дотрын өвчнүүдийг анагаахад хэрэглэдэг арилгах, амарлиулах эм, тэдгээрийн найрлагад ордог ургамал, амьтан, эрдсийн гаралтай түүхий эдүүд, нэмэр, хачир эмүүдийг зөв таних, шинжлэх ухааны болон англи, монгол, төвөд, орос нэршлүүд
2. Уламжлалт эм, эмийн түүхий эдийн амт, эрдэм, чадал, заалт, номхотгол
3. Уламжлалт эм, эмийн түүхий эдэд агуулагдах биологийн идэвхт бодисын бүтэц, үйлдэл
4. Уламжлалт эм, эмийн түүхий эдийг хэрэглэх арга, эм уух ёс
5. Уламжлалт аргаар эм найруулах, жорыг задлан шинжлэх, эмд хөлөг, хачир хийх ёс аргад суралцах

ТОЙРОЛТ 3. МОНГОЛ АНАГААХ УХААНЫ ОНОШ ЗҮЙ

Тойролтын агуулга:

1. Өвчний бэлгэ чанар, шалтгаан, нөхцөл, туслах, хорлохыг асуух аргыг эх сурвалж, судалгааны бүтээлүүдээс судлах
2. Сүр сүлд, цог жавхаа, нүүр, царай, арьс хөрс, хаван, цөв, хир, шээс, таван цэцэг зэргийг үзэж шинжлэх аргыг эх сурвалж, судалгааны бүтээлүүдээс судлах
3. Дан, хавсарсан, хурсан өвчнүүд, зонхилон тохиолдох дотрын өвчнүүдийн үед илрэх шинж тэмдгүүдийг эх сурвалж, судалгааны бүтээлүүдээс судлах
4. Бэлчир орон тэмтрэх, судас барих, судасны эндүүрлийн талаар эх сурвалж, судалгааны бүтээлүүдээс судлах

5. Уул тал завсрын халуун, хий шар бадганы гурван боомт, өвчний 10 их баримтлал, өвчнийг шинжлэн тодруулах хэрэгт 4 товчийг эх сурвалж, судалгааны бүтээлүүдээс судлах
6. Уламжлалт анагаах ухааны оношилгооны аргуудын судалгаа хийх

ТОЙРОЛТ 4. МОНГОЛ АНАГААХ УХААНЫ ЗАСАЛ

Тойролтын агуулга:

1. Ханах ёс, ханах судаснууд, нэршил, байршил
2. Ханахад тохирох, эс тохирох өвчин бэлтгэл, муу цусны тухай
3. Судсыг боох, ханах арга, онцлог, оньс, гарах хүндрэл
4. Төөнөх заслыг хийх, төөнөх бэлчрүүд, нэршил, байршил, онцлог, гарах хүндрэл, биеийн арын болон өврийн төөнөх бэлчир, тодорхойлох арга, монгол, төвөд нэршил, тохирох өвчин, онцлог, гарах хүндрэл
5. Дэвтээлэг засал, байгалийн болон хиймэл рашаан, рашааныг гадуур ба дотуур хэрэглэх, рашааны биед үзүүлэх нөлөө, рашаанд үйлчлүүлэгчийг бэлтгэх, оруулах
6. Шавар эмчилгээ, ангилал, үйлдэл, тохирох өвчин, онцлог, гарах хүндрэл
7. Соруул засал, эмчилгээний үйлдэл, хийх арга, самнуур
8. Шивүүр хийх арга хийх арга, анхаарах зүйл
9. Хатгах засал хийх арга, анхаарах зүйл
10. Түрэм, хийх арга, анхаарах зүйл
11. Жин засал, халуун хүйтэн жин, хийх арга, хэрэглэх материал
12. Хэвлийн ба судасны туулга хийх арга, онцлог, гарах хүндрэл, хэрэглэх жор найралтууд
13. Бөөлжүүлэх засал хийх арга, тохирох өвчин, онцлог, гарах хүндрэл, хэрэглэх жор найралтууд

ТОЙРОЛТ 5. ЛАБОРАТОРИЙН АРГА ЗҮЙ

Тойролтын агуулга:

1. Цусны эс, цусны хий, эрдэс, нүүрс-ус, уураг, өөх тос, фермент, нөсөөт бодисын солилцоо тэдгээрийн хямрал, лабораторийн оношилгооны ажилбарын үндэс, зарчим, арга технологи
2. Эрхтэн тогтолцооны эмгэгүүдийн үеийн эмнэл зүйн шинжилгээний дүгнэлт, оношийг баталгаажуулах
3. Лабораторийн шинжилгээний өмнөх, шинжилгээний, шинжилгээний дараах үйл явц
4. Шинжилгээний сорьц авах: цус, шээс, бусад материал авах, бэхжүүлэх, тээвэрлэх, хадгалах арга
5. Шинжилгээний сорьц боловсруулах: ийлдэс, сийвэн ялгах, дүүгүүрдэх, хөргөх, хөлдөөх, хатаах аргууд
6. Шинжилгээний сорьц тээвэрлэх

ТОЙРОЛТ 6. МОНГОЛ АНАГААХ УХААНЫ ДОТОР ӨВЧИН I

Тойролтын агуулга:

1. Язгуурын хий өвчнүүд

2. Язгуурын шар өвчнүүд
3. Язгуурын бадган өвчнүүд
4. Язгуурын бор өвчнүүд
5. Цусны өвчнүүд
6. Шар усны өвчнүүд
7. Их архаг өвчнүүд (эс шингэсэн, бэтэг, хаван)
8. Зүрхний өвчнүүд
9. Уушгины өвчнүүд
- 10.Элэгний өвчнүүд
- 11.Дэлүүний өвчнүүд
- 12.Бөөрний өвчнүүд
- 13.Ходоодны өвчнүүд
- 14.Цөсний өвчнүүд
- 15.Гэдэсний өвчнүүд
- 16.Олгойн өвчнүүд
- 17.Давсгийн өвчнүүд

ТОЙРОЛТ 7. МОНГОЛ АНАГААХ УХААНЫ ДОТОР ӨВЧИН II

Тойролтын агуулга:

1. Хэсэг бусаг өвчнүүд
1. Хамт төрсөн яр өвчнүүд
2. Эмэгтэйчүүдийн өвчнүүд
3. Эрэгтэйчүүдийн өвчнүүд
4. Ад донгийн өвчнүүд
5. Хорын өвчнүүд
6. Халуун өвчнүүд
7. Уламжлалт анагаах ухаанаар хүчжүүлэх, шимжүүлэх

ТОЙРОЛТ 8. ЯАРАЛТАЙ ТУСЛАМЖ

Тойролтын агуулга:

1. Яаралтай тусламж үзүүлэх техникүүдийг эзэмших
2. Амилуулах тусламж үзүүлэх, амилуулах тусламжийн шаардлагатай болон зогсоох үеийг мэдэх
3. Биеийн болон сэтгэл санааны цочмог өвчлөлтэй үйлчлүүлэгчид тусламж үзүүлэх
4. Цочмог гэмтэл авсан үйлчлүүлэгчид тусламж үзүүлэх
5. Хүүхдэд яаралтай тусламж үзүүлэх
6. Уламжлалт анагаах ухааны аргаар амь тэнссэн байдлыг үнэлэх: судас, хэл, шээс оношилгоо, үхлийн шинжийг тогтоох
7. Уламжлалт анагаах ухааны аргаар амь тэнссэн үед шаардлагатай засал эмчилгээ хийх, анхны тусламж үзүүлэх: бэлчрийг сонгож зүү тавих, төөнө, эмт ба янжуурын төөнө хийх, ханах, самнах, шивүүр хийх, жин тавих, түрхлэг хийх, бариа, татлага хийх, боолт хийх

8. Уламжлалт анагаах ухааны аргаар амь тэнссэн үед шаардлагатай эмийн эмчилгээ хийх: суулгалт, бөөлжилтийг зогсоох, артерийн даралтыг хэвд нь оруулах, зүрхний хэм зохицуулах, цус тогтоох, тархины даралт бууруулах

ТОЙРОЛТ 9. УЛАМЖЛАЛТ АНАГААХ УХААНЫ ӨВЧНӨӨС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ ЁС

Тойролтын агуулга:

1. Өвчнөөс сэргийлэх тухай уламжлалт анагаах ухааны сургаал
2. Эрүүл болон эмгэгийн тухай ойлголт, эрүүл мэндэд нөлөөлж байгаа хүчин зүйлүүд, өдөр тутмын явдал мөрөөр өвчнөөс урьдчилан сэргийлэх арга, идээг цээрлэх, идээний хэмжээг тохируулах ёс, идээ ундаагаар өвчнөөс урьдчилан сэргийлэх арга
3. Сэтгэл засал эмчилгээ
4. Бие махбодын өвөрмөц чанарын тухай ойлголт, өвөрмөц чанарт тохирсон идээ ундаа, явдал мөрөөр өвчнөөс урьдчилан сэргийлэх

Загвар 1

Ажлын байрны сургалт (*On-the-Job Training*)

Аргачлал	Суралцагч эмчийн тоо	Үргэлжлэх цаг, давтамж	Сургалт явагдах газар	Үйлчлүүлэгч/Хэрэглэгдэхүүн
Амбулаторийн үзлэг хийх	1	1-2 цаг, 7 хоногт 1-3 удаа	Амбулатори	Үйлчлүүлэгч
Хяналтын тойрон үзлэг хийх	3-5	1 цаг, өдөр бүр	Тасаг	Үйлчлүүлэгч
Сургалтын тойрон үзлэг хийх	1-2	1 цаг, 7 хоногт 1 удаа	Сургалтын өрөө, танхим	Үйлчлүүлэгч
Гардан үйлдэл хийх	Өдөр бүр 3-5	Шаардагдах хугацаагаар	Эмчилгээний өрөө	Үйлчлүүлэгч

Хяналтын тойрон үзлэг:

Хэвтэн эмчлүүлж байгаа үйлчлүүлэгчийн биеийн байдлыг суралцагч эмч нь эмнэл зүйн сургагч багшид танилцуулна.

Үүний тулд суралцагч эмч нь урьдчилан бие даан өвчний түүх, сувилагчийн тэмдэглэлийг үзэж танилцан, үйлчлүүлэгчтэй уулзаж асуумж цуглуулж (ганцаарчилсан үзлэг), эмнэл зүйн сургагч багшид (бусад эмч) танилцуулахад бэлдэнэ. Танилцуулга хийхдээ хувь хүний мэдээллийг анхаарна. Танилцуулгыг сургалтын өрөө, танхим эсвэл үйлчлүүлэгчийн өрөөнөөс гадна хийх ба үйлчлүүлэгчийн орны дэргэдэх тойрон үзлэгийг эмнэл зүйн сургагч багштай (бусад эмч) хамт хийнэ. Хяналтын тойрон үзлэгээр үйлчлүүлэгчээс асуумж авах, үзлэг хийх аргад суралцана.

Сургалтын тойрон үзлэг:

Сургалтад тохиромжтой 1-2 үйлчлүүлэгчийг сонгож, биеийн байдлыг нь суралцагч эмч танилцуулах ба бусад оролцогчид (хамтран суралцагч эмч, эмнэл зүйн сургагч багш, бусад эмч) асуулт тавьж, хэлэлцүүлэг өрнүүлнэ. Нэг тохиолдолд 30-60 минут зарцуулна. Үүний дараа үйлчлүүлэгчийн орны дэргэд үзлэг хийнэ. Хэлэлцүүлгийн явцад эмнэл зүйн таамаглал дэвшүүлэх, онош тавих зэрэгт суралцана.

Загвар 2

Танхимын сургалт (*Off-the-Job Training*)

Аргачлал	Суралцагч эмчийн тоо	Үргэлжлэх цаг, давтамж	Сургалт явагдах газар	Хэрэглэгдэхүүн
Семинар	25 хүртэл	7 хоногт 3-5 удаа, 60 минут	Сургалтын анги, танхим	Тохирох сэдвүүдээр танилцуулга
Лекц	25 хүртэл	7 хоногт 2-5 удаа, 60 минут	Сургалтын анги, танхим	Слайд
Журнал клуб	25 хүртэл	7 хоногт 1 удаа, 60 минут	Сургалтын анги, танхим	Слайд, эрдэм шинжилгээний өгүүлэл
Симуляци (дуураймал орчин)	5 хүртэл	7 хоногт 1 удаа, 60 минут	Ур чадварын өрөө, яаралтай тусламжийн өрөө	Хамтран суралцагч эмч, манекен
Бие даалт	1	Тохиромжтой, чөлөөт цаг	Гэртээ, номын сан	Ном, интернэт
Дүрд тоглох	5 хүртэл	7 хоногт 1 удаа, 60 минут	Ур чадварын өрөө, яаралтай тусламжийн өрөө	Хамтран суралцагч эмч

Загвар 3

Үйл ажиллагааны хуваарь

Цаг	Даваа	Мягмар	Лхагва	Пүрэв	Баасан
8:00	Ганцаарчилсан үзлэг	Ганцаарчилсан үзлэг	Ганцаарчилсан үзлэг	Ганцаарчилсан үзлэг	Ганцаарчилсан үзлэг
8:00 9:00	Хяналтын тойрон үзлэг	Хяналтын тойрон үзлэг	Хяналтын тойрон үзлэг	Хяналтын тойрон үзлэг	Хяналтын тойрон үзлэг
9:00 11:00	Лекц	Семинар	Лекц	Семинар	Семинар
11:00 13:00	Бие даалт	Амбулаторийн үзлэг	Амбулаторийн үзлэг	Бие даалт	Дүрд тоглох
14:00 15:00	Журнал клуб	Бие даалт	Сургалтын тойрон үзлэг	Амбулаторийн үзлэг	Бие даалт
14:00 17:00	Гардан үйлдэл	Гардан үйлдэл	Гардан үйлдэл	Гардан үйлдэл	Гардан үйлдэл

ДОЛОО. ҮНЭЛГЭЭ, ЭРГЭН ЗӨВЛӨГӨӨ

7.1 Суралцагч эмч ба хариуцагч

Сургалтын 2 жилийн хугацаанд суралцагч эмч бүрд хэрхэн ахин дэвшиж байгаа, хэрхэн сайжруулах тухай эргэн зөвлөгөө өгөх, суралцагч эмчийн хувийн төлөвлөгөөний талаар зөвлөлдөх, тэднийг хариуцан ажиллах хүн (mentor) цаашид "хариуцагч" гэх)-ийг оноож хуваарилна. Суралцагч эмч нь сургалт эхлэх үед хариуцагчтай уулзах ба цаашид 2-3 сар тутамд 1 удаа уулзаж ярилцан, үнэлгээтэй танилцаж, эргэн зөвлөгөө авна.

7.2 Суралцагч эмч ба эмнэл зүйн сургагч багш

Суралцагч эмч ба эмнэл зүйн сургагч багш

Суралцагч эмчийг тойролт бүрд сургалт удирдах эмнэл зүйн сургагч багш оноож хуваарилна.

- Суралцагч эмч нь тухайн тойролт эхлэхээс өмнө эмнэл зүйн сургагч багштай уулзаж, тойролтын хугацаанд тавьсан зорилтоо ярилцана.
- Суралцагч эмч нь тойролтын явцад тавьсан зорилтод хүрэхийн тулд дутагдаж байгаа зүйлийн тухай эмнэл зүйн сургагч багштай ярилцана.
- Суралцагч эмч нь тойролт дуусахад эмнэл зүйн сургагч багштай ярилцлага хийж, сургалттай холбоотой асуудлаар заавар, зөвлөгөө авна.

7.3 Үнэлгээний арга

7.3.1 Төгсөлтийн шалгалт

"Монголын уламжлалт анагаах ухааны Дотор судлал"-ын сургалтын төгсөлтийн шалгалтыг өгнө. Шалгалтад тэнцсэн тохиолдолд "Монголын уламжлалт анагаах ухааны Дотор судлалын эмч"-ийн үнэмлэх олгоно.

7.3.2 Ажлын байранд суурилсан үнэлгээ (*Workplace-based Assessment*)

360 хэмийн үнэлгээ (*360-Degree Assessment*):

Суралцагч эмчийн зохион байгуулагч, манлайлагч (*leader*) байх зэргийг үнэлэхэд хэрэглэнэ. 2 жилийн сургалтын дунд үе болон төгсөх үед хийнэ. Тойролтыг удирдсан эмнэл зүйн сургагч багш, сувилахуйн мэргэжилтэн, тухайн тасаг, нэгжийн хамтран ажилласан эмч, эмнэлгийн мэргэжилтэн, үйлчлүүлэгч зэрэг нийт 5 хүн тус тусдаа үнэлнэ. Үнэлгээ хийх хүнийг сургалтын албанаас сонгоно. Үнэлгээний дүнг суралцагч эмч болон хариуцагчид танилцуулж, үнэлгээнд үндэслэсэн эргэн зөвлөгөөг хариуцагчаас суралцагчид өгнө.

Mini-CEX/Эмнэл зүйн дасгал үнэлгээ (*Mini-Clinical Evaluation Exercise*):

Зайлшгүй таньж мэдэх 32 шинж тэмдгээс тойролт бүрд 8-аас доошгүй шинж тэмдгийг тус бүр 3-аас доошгүй удаа, нийт 15-аас доошгүй удаа үнэлгээ хийнэ. Өөр тойролтод ижил шинж тэмдгээр үнэлгээ хийж болно. (Жишээ нь: Үндсэн зургаан өвчний тойролтод хэвлийгээр өвдөх шинж тэмдгийг оролцуулан 5 шинж тэмдгээр үнэлгээ хийсэн бол дотор өвчин, эс шингэсэн өвчний тойролтод ч хэвлийгээр өвдөх шинж тэмдгийг оролцуулан 5 шинж тэмдгээр үнэлгээ хийж болно).

Үнэлгээ хийх эмчийг эмнэл зүйн сургагч багш эсвэл тухайн тасаг, нэгжийн туршлагатай эмч нараас суралцагч эмч өөрөө сонгох ба тухайн сонгосон эмч шууд ажиглаж, үнэлгээ хийсний дараа үр дүнг суралцагч эмчид танилцуулж, цаашид хэрхэн сайжруулах зөвлөгөө заавал өгнө.

Гардан үйлдлийн ур чадварын шууд ажиглалт (*DOPS (Direct Observation of Procedural Skills)*):

Зайлшгүй сурах 35 гардан үйлдлээс 30-өөс доошгүйг хийж чаддаг болсныг эмнэл зүйн сургагч багш нотолж, баталгаа өгөх хүртэл давтан үнэлгээ хийнэ.

Үнэлгээ хийх эмчийг эмнэл зүйн сургагч багш эсвэл тухайн тасаг, нэгжийн туршлагатай эмч нараас суралцагч эмч өөрөө сонгох ба тухайн сонгосон эмч шууд ажиглаж, үнэлгээ хийсний дараа үр дүнг суралцагч эмчид танилцуулж, цаашид хэрхэн сайжруулах зөвлөгөө заавал өгнө.

Порфолио үнэлгээ (Portfolio Assessment):

Суралцагч эмч нь сургалтын хугацаанд суралцсан лекц, уламжлалт анагаахын тусламж үйлчилгээний сургалтын үеэр эрүүл мэндийн сургалт, сурталчилгаа хийсэн материал зэрэг сургалттай холбоотой бусад бичиг баримтыг үр дүн болгож хадгална.

7.4 Үнэлгээний дүнг хянах

- 360 хэмийн үнэлгээний дүнг сургалтын алба хяналт тавьж, хадгална. Үнэлгээний дүнг суралцагч эмч, хариуцагчид танилцуулах ба бусадтай хуваалцахгүй байхыг анхааруулна.
- Mini-CEX болон DOPS үнэлгээний дүнг суралцагч эмч өөрөө хадгална.
- Портфолиод үнэлгээ, эмнэл зүйн сургагч багштай зөвлөлдсөн бусад асуудал, өгсөн зөвлөгөөг бичиж тэмдэглэн хадгална.
- Суралцагч эмч нь тойролт бүрийн төгсгөлд Mini-сех болон DOPS үнэлгээний дүнг сургалтын албанд хүлээлгэн өгнө.
- Сургалтын алба үнэлгээний дүнг сургалтын хяналтын зөвлөлд танилцуулах ба сургалтын төгсгөлд хариуцагчаас суралцагч эмчид зөвлөгөө өгнө.

7.5 Сургалтын төгсөлтийг шийдвэрлэх

- Тойролт бүрд хийгдсэн Mini-сех болон DOPS үнэлгээний дүнг нэгтгэсний үндсэн дээр суралцагч эмчийг тухайн тойролтыг төгсгөх эсэх шийдвэрийг сургалтын хяналтын зөвлөл гаргана. Сургалтын хяналтын зөвлөл нь тойролт бүрд хийгдсэн Mini-сех болон DOPS үнэлгээний дүн, 360 хэмийн үнэлгээний нэгдсэн дүн, суралцагчийн сургалтын ирц, зайлшгүй таньж мэдэж суралцах шинж тэмдэг, өвчний тохиолдол, гардан үйлдлийн тоог харгалзан сургалтын төгсөлтийг эцсийн шийдвэрийг гаргана. Шийдвэр гаргах шалгуур нь:
- Зайлшгүй таньж мэдэх 32 шинж тэмдгээс 2 жилийн турш 25-аас доошгүйг оношилж, эмчлэн туршлага хуримтлуулсан байна. Зайлшгүй туршлага хуримтлуулсан байх шаардлагатай өвчний тохиолдлын тоо нь :
 - * Тойролт бүрд заагдсан өвчний бүх тохиолдлыг тус бүр 5-аас доошгүй удаа үзэж, туршлага хуримтлуулсан байна.
 - * Зайлшгүй суралцах 35 гардан үйлдлээс 2 жилийн турш 30-аас доошгүйг хийж гүйцэтгэн, туршлага хуримтлуулсан байна.
- Тойролт бүрийн төгсгөлд эсвэл 2 жилийн сургалтын эцэст суралцагчийг төгсгөх боломжгүй гэсэн шийдвэр гарсан тохиолдолд шалтгаан, цаашид сургалтыг хэрхэн төгсгөх талаарх шийдвэр, зөвлөмжийг сургалтын алба болон хариуцагчаас тухайн суралцагч эмчид тайлбарлаж өгнө.

НАЙМ. ХЭРЭГЖҮҮЛЭЛТ

(Хөтөлбөрийг нэвтрүүлэх ба хэрэгжүүлэх)

8.1 Сургалтын хяналтын зөвлөл

- Сургалтын албаны мэргэжилтэн, эмнэлгийн тусламж, үйлчилгээний байгууллагын дэд дарга, амбулатори - уламжлалт эмчилгээний тасгийн хариуцагч, тухайн тойролтын сургалт хариуцагч, сувилахуйн албаны төлөөлөл, эмнэлгийн захиргааны албаны төлөөлөл, суралцагч эмчийн төлөөллөөс бүрдэнэ. Сургалтын хяналтын зөвлөл нь эмнэлгийн тусламж, үйлчилгээний байгууллагын даргын шууд удирдлага дор ажиллана.
- Сургалтын хяналтын зөвлөл нь сар бүр хуралдана.
- Сургалтын хяналтын зөвлөл нь суралцагч эмчийн сургалт, тулгарсан асуудалтай танилцах, суралцагч эмчтэй холбоотой бүх асуудлыг ярилцаж, шийдвэрлэх арга замыг судалдаг бүтэц байна.
- Сургалтын хяналтын зөвлөлийн гишүүд нь сургалтыг илүү сайжруулахын тулд өөрийн мэдлэг, боловсролоо дээшлүүлэхийг зорьж ажиллана.

8.2 Хөтөлбөрийн хяналт

- Сургалтын алба хөтөлбөрт 5 жил тутамд үнэлгээ хийнэ.
- Хөтөлбөр хэрэгжүүлэхэд шаардлагатай сургалтын төлөвлөгөө гаргах, эмнэл зүйн сургагч багшид чиглэсэн сургалт (Faculty Development), суралцагч эмчийн нийгмийн асуудалд дэмжлэг үзүүлэх, шаардагдах санхүүжилтийг төсөвт тусгах зэргийг сургалтын алба хариуцна.

8.3 Сургалтын танилцуулга(*Orientation*)

Сургалт эхлэхийн өмнө тойролт бүрийн сургалтын төлөвлөгөө (*Program*) болон хөтөлбөрийн (*Curriculum*) агуулгын уялдааг тодорхой ойлгох, сургалт эрхлэх байгууллага (эмнэлэг, эрүүл мэндийн төв), түүний үйл ажиллагаа, эмчилгээ, оношилгооны аюулгүй байдал, халдвар хамгааллын тухай суралцагч эмчид гүнзгий ойлголт өгөх зорилго бүхий танилцуулга хичээлийг зохион байгуулна.

360 ХЭМИЙН ҮНЭЛГЭЭНИЙ ХУУДАС

Суралцагч эмчийн нэр: _____

Үнэлгээ хийгч: Эмнэл зүйн сургагч багш Сувилагч Бусад _____

Суралцагч эмчийг ажигласны үндсэн дээр, бусдаас сонссон, мэдсэн зүйл дээр бус, суралцагч эмчийн зан үйлийг хэр давтамжтай байсныг өөрийнхөө ажигласнаар оноо тавина уу.

<input type="checkbox"/> NA	<input type="checkbox"/> 1	<input type="checkbox"/> 2	<input type="checkbox"/> 3	<input type="checkbox"/> 4	
Үнэлэх боломжгүй	Ховор (≤19)	Заримдаа (20-49%)	Ихэнхдээ (50-79%)	Бараг бүгд (≥80%)	
Үйлчлүүлэгч/гэр бүлийн хувийн асуудлыг хүндэтгэдэг	<input type="checkbox"/> NA	<input type="checkbox"/> 1	<input type="checkbox"/> 2	<input type="checkbox"/> 3	<input type="checkbox"/> 4
Эмнэлгийн бичиг баримтыг бүрэн гүйцэт, гаргацтай, цаг хугацаанд нь хөтөлдөг.	<input type="checkbox"/> NA	<input type="checkbox"/> 1	<input type="checkbox"/> 2	<input type="checkbox"/> 3	<input type="checkbox"/> 4
Орон нутгийн хүн амын эрүүл мэндийн асуудалд өөрийн санаачилгаар хувь нэмрээ оруулдаг.	<input type="checkbox"/> NA	<input type="checkbox"/> 1	<input type="checkbox"/> 2	<input type="checkbox"/> 3	<input type="checkbox"/> 4
Үйлчлүүлэгчийн бие даасан байдлыг хүндэтгэж, үйлчлүүлэгчид тохирсон хамгийн зөв шийдвэрийг гаргахад хичээн зүтгэл гаргадаг.	<input type="checkbox"/> NA	<input type="checkbox"/> 1	<input type="checkbox"/> 2	<input type="checkbox"/> 3	<input type="checkbox"/> 4
Хувь хүний онцлогийг харгалзан үйлчлүүлэгчийг хүндэтгэж эмчилдэг.	<input type="checkbox"/> NA	<input type="checkbox"/> 1	<input type="checkbox"/> 2	<input type="checkbox"/> 3	<input type="checkbox"/> 4
Өөрийн эмнэл зүйн ур чадварыг дээшлүүлэхийн тулд сургалт болон бусад боломжийг алдалгүй ашигладаг.	<input type="checkbox"/> NA	<input type="checkbox"/> 1	<input type="checkbox"/> 2	<input type="checkbox"/> 3	<input type="checkbox"/> 4
Өөрийн уламжлалт анагаах ухааны онолын мэдлэгээ дээшлүүлэхийн тулд бие даан суралцдаг.	<input type="checkbox"/> NA	<input type="checkbox"/> 1	<input type="checkbox"/> 2	<input type="checkbox"/> 3	<input type="checkbox"/> 4
Орон нутаг дахь бусад эмнэлгийн мэргэжилтэнтэй хамтран ажилладаг.	<input type="checkbox"/> NA	<input type="checkbox"/> 1	<input type="checkbox"/> 2	<input type="checkbox"/> 3	<input type="checkbox"/> 4
Эмнэлэг доторх бусад эмч, мэргэжилтэнтэй хамтран ажилладаг.	<input type="checkbox"/> NA	<input type="checkbox"/> 1	<input type="checkbox"/> 2	<input type="checkbox"/> 3	<input type="checkbox"/> 4
Орон нутгийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээнд зохион байгуулах, манлайлах үүрэгтэйг ухамсарладаг.	<input type="checkbox"/> NA	<input type="checkbox"/> 1	<input type="checkbox"/> 2	<input type="checkbox"/> 3	<input type="checkbox"/> 4
Эмнэлэг доторх тусламж, үйлчилгээнд зохион байгуулах, манлайлах үүрэгтэйгээ ухамсарладаг.	<input type="checkbox"/> NA	<input type="checkbox"/> 1	<input type="checkbox"/> 2	<input type="checkbox"/> 3	<input type="checkbox"/> 4

1 эсвэл 4 оноо тавьсан бол тухайн асуултын дагуу саналаа бичнэ үү.

Дүгнэлтийг тодорхой бичих хэрэгтэй. Жишээ нь: "Тэр бол найдваргүй" гэх нь тодорхой биш. Илүү хэрэг болох дүгнэлт бол: "Тэр сүүлийн 3 удаагийн журнал клубийн 2-т нь хэн нэгэнд урьдчилан мэдэгдэлгүйгээр оролцсонгүй."

Өөрөөсөө асуу: "Миний дүгнэлт цаашид сайжрахад нь суралцагч эмчид хэрэг болох уу?"

ЯВЦЫН MINI-СЕХ ҮНЭЛГЭЭНИЙ ХУУДАС

Он,сар, өдөр _____ / _____ / _____

Суралцагч эмчийн нэр: _____

Үнэлэгчийн нэр: _____

Сургалт эрхлэх байгууллага: _____ Нэгж: _____ Газар: Амбулатори
 Эмийн үйлдвэр УА тасаг Бусад _____ Өвчтөний нас: _____ Хүйс: Эр Эм

Үйлчлүүлэгчийн зовуурь: Халуурах Шарлах Толгой өвдөх Ухаан санааны байдал өөрчлөгдөх Татах Ханиалгах Цээжээр өвдөх Дотор муухайрах, бөөлжих, Хоосон огих Хэвлийгээр өвдөх Суулгах Нуруу өвдөх Саажих Хавагнах Үе өвдөх Зүрх зогсох Жихүүцэх Эвшээх, суниах Таван мэдрэхүй үл тодрох Сэтгэл санаа тогтворгүй болох Сүүж бэлхүүс, яс үесээр хатгуулж өвдөх Энд тэндгүй тогтворгүй өвдөх Идээ шингэсний дараа, өглөө үүрээр, үдшийн бүрийд өвчин хөдлөх Аманд гашуун амт амтагдах Идээ шингэх үед өвдөх Хоолонд дургүй болох Бусад

Сайн талууд	Сайжруулахад чиглэсэн зөвлөгөө	Бусад

Сургалтын тухайн үед суралцагч эмчийг ямар түвшинд байгааг ажигласнаа үнэлнэ үү.

Бодит үзлэг хийх шаардлагагүй тохиолдолд тэмдэглэнэ үү

Үнэлгээ	Хангалтгүй	Завсрын	Хангалттай
Өвчний түүх авах			
Бодит үзлэг			
Оношилгоо, эмчилгээний менежмент			
Харилцааны ур чадвар			
Эмнэл зүйн ерөнхий чадвар			

Сайжруулахын тулд зөвшилцөж биелүүлэх үйлдэл

--

Үнэлэгчийн гарын үсэг _____ Суралцагч эмчийн гарын үсэг _____

"Хангалттай" гэж тодорхойлоход хэрэглэх үзүүлэлт	
Өвчний түүх авах	<ul style="list-style-type: none"> • ялган оношилгоо хийхүйц дэлгэрэнгүй асуумж авдаг • үйлчлүүлэгчийн хэрэгцээг илрүүлж, хариу үзүүлдэг. • Үйлчлүүлэгчийн дохио зангааг ойлгож, тохиромжтой хариу үзүүлдэг.
Бодит үзлэг	<ul style="list-style-type: none"> • ялган оношилгоо хийхүйц дэс дараалсан бодит үзлэг хийдэг. • үзлэгийн үед өвчтөнд таатай байдал бүрдүүлэхэд анхаардаг.
Эмнэл зүйн менежмент	<ul style="list-style-type: none"> • зөв онош тавьдаг

	<ul style="list-style-type: none"> • оношилгоо, эмчилгээнд шаардлагатай шинжилгээ төлөвлөж, үр дүнг ашигладаг. • тохирсон эмчилгээг эхлүүлдэг. • тохирсон тасаг, эмнэлэгт шилжүүлдэг, цааш нь хяналт тавьдаг.
Харилцааны ур чадвар	<ul style="list-style-type: none"> • үйлчлүүлэгч, түүний гэр бүл, асран хамгаалагч, төрөл садны хүнийг сайн сонсдог. • үйлчлүүлэгч, түүний гэр бүл, амран хамгаалагч, төрөл садны хүнтэй эелдэг энгийн үг хэллэг хэрэглэж харилцдаг. • үйлчлүүлэгч, түүний гэр бүл, амран хамгаалагч, төрөл садны хүний зовнилыг хуваалцаж, хүндэтгэлтэй ханддаг.
Эмнэл зүйн ерөнхий чадвар	<ul style="list-style-type: none"> • системтэй (харилцан уялдаатай) арга замыг тодорхойлдог. • үйлчлүүлэгчийн таатай, аюулгүй байдлыг хангахад тодорхой идэвх зүтгэл гаргадаг. • би гэр бүлийнхээ хэн нэгнийг энэ эмчээр үйлчлүүлэхийг зөвшөөрч чадна.

ГАРДАН ҮЙЛДЛИЙН УР ЧАДВАРЫН ШУУД АЖИГЛАЛТ (DOPS)-ЫН ҮНЭЛГЭЭ

Он,сар, өдөр _____ / _____ / _____

Суралцагч эмчийн нэр: _____

Үнэлэгчийн нэр: _____

Сургалт эрхлэх байгууллага: _____ Нэгж: _____ Газар: Амбулатори Эмийн үйлдвэр УА тасаг Бусад _____

Гардан үйлдэл: Амилуулах суурь тусламж, зүрх уушгины сэхээн амьдруулалд
 Тариа хийх (судас тариа, булчин тариа, арьсан дор) Зүрхний цахилгаан бичлэг хийх
 Цусан дахь сахрын хэмжээг тодорхойлох Ханах заслын холын бэлтгэл хийх
 Ханах заслын ойрын бэлтгэл хийх Хануурын боолт хийх Ханах засал хийх
 Уул өвсөн төөнө хийх Харандаан төөнө хийх Эмч бодисын төөнө хийх (Монгол төөнө)
 Зүүлэх төөнө засал хийх Хайрцган төөнө хийх Шовгон төөнө хийх
 Хатгуур засал хийх Бүлээн зүү засал хийх Сам соруул засал хийх Соруул засал хийх
 Шивүүр засал хийх Усан дэвтээлэг засал хийх Ороож боох дэвтээлэг хийх
 Илж нухлах засал хийх Шимжүүлэх бариа хийх Жин засал хийх

Одоог хүртэл суралцагч эмчийн тухайн гардан үйлдлийг хийсэн тоо

Үнэлгээ	Хангалтгүй	Завсрын	Хангалттай	Ажиглагдаагүй/ үнэлэх боломжгүй
Хийх гэж буй үйлдлээ үйлчлүүлэгчид тайлбарладаг. Үйлчлүүлэгчээс зөвшөөрлийн хуудас авдаг.				
Гардан үйлдэл хийх бэлтгэлийг зохистой хийдэг.				
Халдваргүйжүүлэх үйлдлийг гүйцэтгэдэг, багаж хэрэгслийг аюулгүй хэрэглэдэг.				
Арга техникийг чадварлаг гүйцэтгэдэг.				
Өөрийн чадахгүй үйлдлийг ойлгож, шаардлагатай үед тусламж дууддаг.				
Багаж хэрэгсэл, материалыг цэвэрлэдэг				
Шаардлагатай бичиг баримтыг гүйцэт бичдэг.				
Гардан үйлдэл хийх ерөнхий чадвар				

Зөвлөмж:

- Сайн тал:
- Сайжруулах тал:

Бусад санал:

Сайжруулахын тулд зөвшилцөж, биелүүлэх үйлдэл:

Үнэлэгчийн гарын үсэг: _____

Суралцагч эмчийн гарын үсэг: _____

НОМ ЗҮЙ

Эрүүл мэндийн Сайдын тушаал, стандарт, журмууд:

1. Эрүүл мэндийн сайдын 2017 оны тушаал

Дотоодын хэвлэл, ном, сурах бичиг, сурвалж зохиол:

2. Анагаах ухааны дөрвөн үндэс
3. Дармаманрамба Лувсанчойдог. Алтан хадмал
4. Дармаманрамба Лувсанчойдог. Бэрх оньсны очир зангилаа тайлагч
5. Лувсанчоймбол. Тус амгалангийн шимийн хураангуй
6. Сурхарва Лодойжалба. Дээдсийн таалал
7. Ишбалжир. Дөрвөн рашаан
8. Лүнригдандар. Арүүрийн эрхэс
9. Чойжамц. Маш гайхамшигт хуримын сан
10. Д.Цэнд-Аюуш, Т.Алимаа, Ч.Батнайрамдал, нар. Монгол анагаах ухааны онол 2017
11. Ч.Батнайрамдал. Төвөд хэл сурах бичиг. 2016
12. У.Лигаа. Монгол орны эмийн ургамлыг өрнө дорнын анагаах ухаанд хэрэглэхүй
13. Б.Дагвацэрэн, Г.Наранцэцэг. Ургамлын эмийн зохистой хэрэглээний гарын авлага
14. Б.Хүрэлчулуун, Д.Суран. Монгол эмд хэрэглэдэг ургамлын түүхий эдийн зурагт лавлах
15. Б.Хүрэлчулуун, Ө.Батчимэг. Монгол орны ургамлын гаралтай зарим эмийн түүхий эдийн лавламж
16. Б.Хүрэлчулуун, Ө.Батчимэг. Монгол эмд хэрэглэгддэг гадаад ургамлын түүхий эд
17. Б.Пүрэвсүрэн, З.Мэндсайхан. Монгол эмийн эрдэс чулуу
18. Ц.Хайдав, Ц.Шерхан. Монгол ардын эмнэлэгт хэрэглэгдэж байсан зарим эрдэс
19. Ц.Хайдав. Ардын эмнэлэгт хэрэглэгддэг амьтны гаралтай эм. I, II боть
20. Ч.Баавгай, Б.Болдсайхан. Монголын уламжлалт анагаах ухаан
21. С.Олдох, Б.Цэрэнцоо, П.Батхуяг. Монгол эмийн судлал
22. Я.Ганбаяр. Монгол эмийн жорын гарын авлага
23. Дундад улсын нэвтэрхий толь
24. Б.Лувсан. Монгол эм судлал
25. Ч.Сүрэнжав. Монгол анагаах ухааны эм найрлагын судлал
26. Юй Чин Шиян. Монгол эмийн жор
27. Уламжлалт эмт бодис жорын хяналтын лавламж
28. Д.Цэрэндагва, Б.Балдансамбуу. Монголын уламжлалт анагаах ухааны дотор өвчний онош зүй
29. С.Сээсрэгдорж нар. Монголын уламжлалт анагаах ухааны өвчнийг анагаах увдис
30. Ү.Байгалмаа. Монголын уламжлалт анагаах ухааны оношилгоо
31. З.Мэндсайхан, Б.Пүрэвсүрэн. Уламжлалт эмнэлгийн оношилгооны аргууд
32. Д.Нацагдорж, Г.Одонцэцэг. Онош зүй

33. Өвчний олон улсын Х ангилал
 34. Ч.Чимэдрагчаа, Т. Алимаа, Н.Төмөрбаатар. Монгол анагаах ухааны идээ ундаан засал
 35. Б.Дагвацэрэн, Ө.Батчимэг, Т.С.Варламова, Г.Наранцэцэг. Өвчнөөс урьдчилан сэргийлэх уламжлалт анагаах ухааны ёс
 36. Н.Оюунцэцэг, Д.Цэнд-Аюуш, Н.Төмөрбаатар, Т.Алимаа. Монгол анагаах ухааны засал
 37. Б.Дагданбазар Монгол хануурын увдис
 38. Д.Цэрэндагва. Ханах засал
 39. С.Сээсрэгдорж нар. Монголын уламжлалт анагаах ухааны өвчнийг анагаах увдис
 40. С.Зина, М. Мягмаржав. Таван засал
 41. Б.Уул. Уламжлалт заслын болор эрхи
 42. Д.Тунгалагтамир. Бариа засал
 43. Н.Туяа. Иллэг засал
 44. Ч.Дондог. Монголын барих арга засал
 45. Н.Төмөрбаатар, С.Сэдэддулам. Зүү төөнө заслын сүвийн хэмжил зүй
 46. Н.Төмөрбаатар. Лекцийн эмхэтгэл. 2003-2009
 47. Н.Төмөрбаатар. Зүү төөнө заслын онолын үндэс
 48. Н.Занди. Иогийн гарын авлага
 49. Ч.Сүрэнжав. Монгол анагаах ухааны эмчилгээний судлал
- Гадаадын хэвлэл, ном, сурах бичиг:**
1. А.Хиранмаяананда. Иогоор өөрийгөө анагаахуй
 2. Шри Шри Рави Шанкар. Патанжали иогийн судар
 3. Шри Шри Рави Шанкар. Аштавакра Гита
 4. Swami Satyananda Saraswati. Asana pranayama mudra bandha
 5. Sivananda yoga Vedanta center
 6. International Classification of organ systems tumors. Volumes. Geneva. WHO
 7. Гаваа Лувсан. Традиционные и современные аспекты восточной медицины. Москва. 2000
 8. Acupuncture a comprehensive text. Shanghai college of traditional medicine. Eastland Press. 2005
 9. Wang Xuetai. Research on the origin and development of Chinese acupuncture and moxibustion
 10. Anton Jayasuriya. Clinical acupuncture. New delhi
 11. Zhang Enqin. Chinese acupuncture and moxibustion. Shanghai University. 1996
 12. Дэлхийн эрүүл мэндийн байгууллага, номхон далайн баруун эргийн бүсийн товчоо зүү төөнө заслын сүвийн хэмжил зүйн стандарт: Монгол хэл дээрх албан ёсны хувилбар
 13. Benjamin Kligler. Integrative medicine: Principles for practice
 14. David Rakel. Integrative medicine
 15. Michael H Cohen, Mary Ruggie, Marc S Micozzi. The practice of integrative medicine